

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалын код 13.100

|                                                                                                   |                        |
|---------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага | MNS 5079 : 202x        |
| Occupational Safety and Health. General Safety Requirements for Loading and Unloading Operations  | MNS 5079:2001-ын оронд |

Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2025 оны .. оны .-р сарын ..-ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт ... оны .... дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн хүчинтэй. Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

Энэ стандартаар ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтооход хамаарна.

### 2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

*MNS 4970. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Эргономик. Гараар гүйцэтгэх ажлын үеийн өргөх ачааны жингийн зөвшөөрөх дээд хэмжээ*

*MNS ISO 13688. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага*

*MNS 4931. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал*

*MNS 4930. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага*

*MNS 4990 Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ*

*MNS 3084. Ачилт буулгалт, сэлгээний ажлын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага*

*БНБД 12-03-04. Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм*

### 3 Ерөнхий шаардлага

3.1 Ачиж буулгах ажлыг энэ стандарт болон төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бусад норматив, техникийн баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

3.2 Тусгай зориулалтын ачаа ачих, буулгах ажлыг гүйцэтгэхдээ Дэд бүтцийн улсын хяналтын албанаас баталсан аюулгүйн ажиллагааны нэмэгдэл

шаардлагаар тогтоосон журмыг баримтална.

3.3 Ачиж, буулгах ажлыг зориулалтын өргөх, тээвэрлэх тоног төхөөрөмж болон механикжсан хэрэгсэлийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

3.4 Ачааг гараар өргөх, зөөх үед түүний аюулгүй ажиллагааны талаар мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг биелүүлж ажиллана.

#### **4. Технологийн үйл ажиллагааны явцад тавих шаардлага**

4.1 Ачиж, буулгах ажлыг технологийн карт, заавар, тухайн ажлыг гүйцэтгэх үед тавих аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан дүрэм, журам, норматив-техникийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ

4.2 Ачиж буулгах ажлын байранд анхааруулга, дохио, аюулгүй ажиллагааны тэмдэг тавигдсан байна.

4.3 Ачиж, буулгах ажлын байранд замын хөдөлгөөний (төмөр зам, усан замын тээвэрт мөрдөж байгаа) тэмдгүүдийг байрлуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулсан байна.

4.4 Ачиж буулгах ажлын байранд замын хөдөлгөөний / төмөр зам, автозамд мөрдөж байгаа/ тэмдэгтүүдийг байрлуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулсан байна.

4.5 Ачиж, буулгах ажлын байрны ажлын бүсийн агаар дахь хортой хий, уур, тоосны хэмжээ нь MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

4.6 Ачааг тээврийн хэрэгсэлд ачих, буулгах, өргөж, тээвэрлэх төхөөрөмжөөр шилжүүлэх үед ачаа унаж болох бүсэд тээврийн хэрэгсэл болон хүн ажиллахыг хориглоно.

4.7 Ачааг төмөр замын дагуу байрлуулахдаа MNS 3084 стандартын шаардлагыг баримтална.

4.8 Хураалтын өндөр нь 1.2м хүртэлх ачааг краны буюу төмөр замын ачаан талын зам, төмрийн гаднах ирмэгээс 2.0 м-ээс багагүй зайд, хураалтын өндөр 1.1 м-ээс их үед 2.5м зайд хураавал зохино.

4.9 Ачаа оосорлолтыг “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ. Овор ихтэй ачаанд ачааны жин, хүндийн төвийн байрлалыг харгалзан тэмдэглэсэн цэгээс болон зориулалтын сэнжнээс оосорлоно. Ачааны хүндийн төвийн байрлал, массын хэмжээ, түүний оосорлох хэсэг зэргийг бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч үйлдвэр, эсвэл ачааг илгээгч байгууллага тэмдэглэсэн байх ёстой.

4.10 Ачааг өргөх буюу шилжүүлэхийн өмнө ачааны тогтвортой байдал, оосорлолтын зөв эсэхийг шалгасан байна.

4.11 Ачааг өрж хураахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Ачааны төрөл, түүний онцлог байдаачааны багц, түүний өрөлтийн тогтвортой байдал өргөх төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
- өрөлт түүний дэргэд ажил гүйцэтгэгчдийн аюулгүй ажиллагаагалын техник

хэрэгсэл, түүнийг ажиллуулагчийн хамгаалах хэрэгсэл

- битүү агуулахын ердийн ба зохиомол салхижуулалт, агаарын солилцоо
- цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүс, эрчим хүч, инженерийн байгууламжийн зангилаанд тавих аюулгүй ажиллагаа
- нуранги ачааг тухайн ачааны гулсалтын өнцөгөөс багагүй налуутай буюу бэх бат хийцийн хаалтаар хашиж хураасан байна.

4.12 Ачааг хураахдаа шахагдаж гэмтэхээс хамгаалсан байна.

- Тасралтгүй ажиллагаатай машин механизмаар ачааг ачих, буулгах ажлыг гүйцэтгэх үед:
- Ачааны өрөлт нь ажлын хэсгүүдэд жигд ачаалал өгөх ба ачааны тогтвортой байдлыг хангасан байх.
- Ажлын хэсгүүдэд ачаа өгөх ба авах ажиллагааг түгээх хүлээн авах зориулалттай байгууламжаар гүйцэтгэнэ.
- Тээвэрлэлтийн үед ачаа унах, холилдох, гэмтэх явдал гаргахгүйн тулд тэдгээрийг зөв байрлуулж, бэхэлсэн байвал зохино. Савтай ширхэгийн ачааг ачих, буулгах үед чингэлэг болон бусад төрлийн багцлах хэрэгслийг ашиглана. Багцлагдсан ачаа нь бэхлэгдсэн байна.

4.13 Чингэлэгийн дээвэр, оосорлох сэнж нь цас, мөс зэрэг гадны зүйлээс цэвэрлэгдсэн байна. Чингэлэгийн бүх сэнжээс оосорлосон байна. Чингэлэгийг гараар оосорлох үед тусгай шат болон ажил гүйцэтгэгчдийн аюулгүй ажиллагааг хангасан бусад төрлийн байгууламжийг хэрэглэнэ.

4.14 Ачааг өргөж, буулгах, шилжүүлэх үед түүний ойролцоо чингэлэгүүд дотор болон дээр нь хүн байхыг хориглоно.

4.15 Төмөрлөг зүйлсийг цахилгаан соронзон буюу өргөх төхөөрөмжийг ашиглан ачих үед өргөж, шилжүүлэх ажлын бүсийг тогтоож, хаалт, хамгаалалт хийнэ. Соронзон үйлчилгээтэй төмөрлөг эдлэлийг өргөж, шилжүүлэх үед багцлах хэрэгсэл хэрэглэнэ.

4.16 Модон материал ачиж, буулгадаг ажлын байрыг мод нурж өнхрөхөөс хамгаалсан төхөөрөмж, хэрэгслээр тоноглогдсон байна.

4.17 Нуранги ачааг механикжсан аргаар ачиж буулгах ба нуралт үүсэхээс болгоомжлон овоолж хураасан ачааг хөндийлж ухахыг хориглоно

4.18 Нуранги ачааг вагоноос буулгахдаа ажиллагсад аюулгүй зайнаас тусгай хэрэгслээр нүхийг онгойлговол зохино. Өндөрлөсөн замд (2.5 м-ээс дээш) байрласан вагоноос нуранги ачааг буулгахдаа тусгай тавцан ашиглан нүхийг онгойлгоно.

4.19 Бункер болон бусад эзэлхүүн савыг нуранги ачаагаар дүүргэх (буулгах) үед тэдгээр савны дээд хэсэгт ажил гүйцэтгэгчид унахаас хамгаалсан тусгай хэрэгсэл (тор, таг, хаалт) байрлуулна.

4.20 Шигдүүлэх чанартай ба гулгалт ихтэй нуранги ачааны дээгүүр явагчдад

зориулж, хашлагатай шат буюу зориулалтын тавцан байрлуулж тавьсан байна. Ажил гйцэтгэгчид нь нуранги ачааны дээгүүр явахдаа хамгаалах оосортой бүсийг ашиглана.

- 4.21 Өөрөө буулгагч автомашинаас нуранги ачааг талбайд буюу нүх шуудуунд асгаж буулгахдаа автомашиныг нүхний ирмэгээс 1м-ээс багагүй зайтай зогсоовол зохино. Өөрөө буулгагч автомашиныг давтаж, нягтруулаагүй ачаан дээгүүр явуулах, тулгуургүй ванданг ашиглан ачааг нь буулгахыг хориглоно.
- 4.22 Тэсэрч, дэлбэрэх, хордуулах аюултай ачааг ачих, буулгах, шилжүүлэх ажлыг дараах нөхцөлд гүйцэтгэнэ.
  - тогтоосон журмаар баталсан баримт бичигттусгасан аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу
  - аюултайн зэрэг нь мэдэгдэж байгаа буюу аюулгүй ажиллах талаар ачаа илгээгч байгууллагаас ирүүлсэн зааврын дагуу тусгайлан сонгосон байранд.
- 4.23 Аюултай ачааны хайрцаг сав нь гэмтэлтэй норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангахгүй байгаа нь тогтоогдсон, анхааруулга, таних тэмдэг тавигдаагүй зэрэг зөрчилтэй байвал аюултай ачаа ачих, буулгах ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно.
  - хордуулах бодисоор бохирдсон өргөж тээвэрлэх төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, агуулах болон ачиж буулгах ажлын байрыг сайтар цэвэрлэж, угааж ариутгасан байвал зохино.
  - цацагдсан буюу асгарсан хордуулах бодисыг цэвэрлэж, саармагжуулсан байна
- 4.24 Ачааны физик, химийн чанарт нөлөөлөх цаг уурын өөрчлөлтийн үед ачиж, буулгах ажлыг зогсоох буюу ажил явуулах аюулгүйн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авна.
- 4.25 Аюултай ачаа тээвэрлэхэд тухайн төрлийн ачаанд зориулагдаагүй тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- 4.26 Амьтан, түүхий эд ба амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ачиж, буулгах ажлыг зөвхөн ачааны шинж чанарын тодорхойлолт байгаа тохиолдолд гүйцэтгэнэ. Ажил эхлэхийн өмнө ачааг мал эмнэлгийн хяналтын байгууллагаар шалгуулсан байна.
- 4.27 Хорио, цээрийн үзлэг хийх шаардлагатай ачааг ачих, буулгах, шилжүүлэхдээ ариун цэврийн шаардлагыг хангасан тусгай талбайд гүйцэтгэнэ.
- 4.28 Амьтан, түүхий эд ба амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ачих, буулгах ажлыг гүйцэтгэсний дараа ажлын байр, эд хогшил оосорлох, хамгаалах хэрэгслийг ариутгасан байна.

## **5. Ачих, буулгах ажлыг гүйцэтгэхэд тавих шаардлага**

- 5.1 Ачиж буулгах ажлыг, өргөж тээвэрлэх механизм ба ачааны ачааллыг даах чадвартай, хатуу тэгш хучилттай тусгаарлагдсан талбайд гүйцэтгэнэ.
- 5.2 Ачиж, буулгах ажлын байр нь орон сууцны барилгаас мөрдөж байгаа нормын

дагуу аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хамгаалалтын бүсээр тусгаарлагдсан байна.

- 5.3 Ачиж, буулгах талбай дээр ачаа хурааж өрөх байрны хязгаар болон ачаа хоорондуур нэвтрэх гарцыг тэмдэглэж үзүүлсэн байна.
- 5.4 Ачиж буулгах ажлын байр, ачааны хоорондуур нэвтрэх гарц нь MNS 4996-2000 стандартад заасны дагуу хүрэлцэх хэмжээний байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.
- 5.5 Гэрэлтүүлэг нь жигд тусгалтай байх ба ажил гүйцэтгэгч нарт гялбуулах нөлөө үзүүлэхээргүй байна. Саравчтай агуулахуудад байрлуулах гэрэлтүүлэх хэрэгслийг ачааны онцлог ба орчны нөхцөлийг харгалзан сонгож авна.
- 5.6 Битүү агуулахад ачиж, буулгах ажлыг гүйцэтгэх орчны агаарын найрлага дахь тоос, хортой бодисын хэмжээ нь MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.
  - Ачиж, буулгах ажлыг гүйцэтгэгч нь ариун цэврийн болон ахуйн байр, цэвэр усаар хангагдсан байна
  - Ачиж, буулгах ажил явуулах талбай нь БНБД 12-03-04. Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм болон Гал түймэртэй тэмцэх тухай Монгол улсын хуульд заасан шаардлагад нийцсэн байна.
  - Цаг уурын нөхцөл, тухайн ажлын байран дахь агаарын температур, салхины хурд зэргээс хамаарч гадаа ажил гүйцэтгэгчдийн ажлыг зогсоох эсвэл ажил гүйцэтгэгч нарыг дулаацахад зориулсан завсарлагааны хугацаа тогтоох асуудлыг тухайн байгууллагын захиргаа мөрдөж байгаа хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж байна.

## **6 Өргөж тээвэрлэх тоног төхөөрөмжийн байрлал болон ашиглалтанд тавих шаардлага**

- 6.1 Ачиж буулгах ажил явуулах, өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж нь MNS 4930 стандартад заасан аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.
- 6.2 Өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж, ачаа оосорлох хэрэгслийг угсарч байрлуулах, бүртгэх, турших, баталгаажуулахдаа Дэд бүтцийн хөгжлийн яамнаас /хуучин нэрээр/ баталсан “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” болон бусад норматив техникийн баримт бичгийг мөрдлөг болгоно.
- 6.3 Краны ашиглалтын паспортанд заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс салхины хурд хэтэрсэн үед, ачаа өргөх краныг ажиллуулахыг хориглоно.
- 6.4 Ачаа буулгах үед өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг
- 6.5 Өөрөө хөдөлж шилжихгүйгээр байрлуулсан байна.

## **7 Ачих буулгах ажлыг гүйцэтгэгч нарт тавих шаардлага**

- 7.1 Өргөж тээвэрлэх тоног төхөөрөмжийг 18 нас хүрсэн аюулгүй ажиллах аргад суралцаж, тухайн тоног төхөөрөмж, машин механизмыг ажиллуулах эрхийн үнэмлэх бүхий хүн ажиллуулахыг зөвшөөрнө.
- 7.2 Ачиж, буулгах ажил гүйцэтгэгчид нь “Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгийн журам”-ын дагуу зааснаар үзлэгт хамрагдсан байна. Амьтан ба амьтны гаралтай түүхий эдийг ачиж буулгадаг ажил гүйцэтгэгч нар мөн журмын дагуу урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн байна
- 7.3 Ачиж буулгах ажлын аюулгүй байдлыг хариуцах инженер техникийн ажилтнуудыг технологийн ажиллагааны онцлог, аюулгүй ажиллагааны шаардлага, өргөж тээвэрлэх тоног төхөөрөмжийн зохион байгуулалт, аюулгүй ажиллах арга, галын аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн ариун цэврийн талаарх мэдлэгийг нь шалгасны дараа үүрэгт ажилд нь томилно.
- 7.4 Ачиж, буулгах ажилд тухайн мэргэжлийн курс төгссөн, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, галын аюулгүй байдлын болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зөвшөөрнө.
- 7.5 Аюултай буюу онц аюултай ачааг ачиж буулгах ажилд хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын талаар тусгай хөтөлбөрийн дагуу суралцаж шалгалт өгч зөвшөөрөгдсөн хүмүүсийг ажиллуулна
- 7.6 Ачиж буулгах ажлыг гүйцэтгэдэг ажилчид нь аюулгүй ажиллагаа ба галын аюулгүй байдлын талаар дараах зааварчилгыг заавал авсан байна. Үүнд:
  - Ажлын байрны анхан шатны (өдөр тутам)
  - Давтан (3 сард 1-ээс доошгүй удаа)
  - Ээлжит бус (Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны
  - зөрчил, осол гарах, технологийн процесс зөрчигдөх үед)
  - Ээлжит бус зааварчилгыг аюултай, хүнд овор ихтэй ачаатай ажиллах үед өгнө.
  - Зааварчилгыг өгсөн авсан тухай тусгай бүртгэл хөтөлж, гарын үсэг авч баталгаажуулна.
- 7.7 Ачиж буулгах ажлыг гүйцэтгэгч нь MNS ISO 13688 стандартын шаардлагыг хангасан хувийн хамгаалах ажлын тусгай хувцас хэрэглэнэ. Амьтан, түүхий эд ба амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ачиж буулгах үед ажил гүйцэтгэгч бүр хамгаалах тусгай хувцас өмссөн байна.
- 7.8 Ачиж буулгах ачааны шинж чанараас хамааруулан ажлын тусгай хувцсанд мөрдөж байгаа нормын дагуу угаалга, хими цэвэрлэгээ, ариутгал хийж сэлбэн засварлаж байна.
- 7.9 Ачиж буулгах ажлыг гүйцэтгэгч нь ажлын байранд дээрээс юм унаж болзошгүй үед хамгаалах дуулга (каска) өмсөх, ажлын байрны агаар тоосорхог, хийн

бохирдолттой нөхцөлд амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгсэл хэрэглэх ба MNS 4931 стандартын шаардлагыг биелүүлж ажиллана.

- 7.10 Хувийн хамгаалах хэрэгслийг олгохдоо, тэдгээрийг хэрэглэх талаар зааж танилцуулсан байна. Хувийн хамгаалах хэрэгсэл нь гэмтэлтэй буюу бохирдсон байвал хэрэглэхийг хориглоно.

**ТӨГСӨВ.**